



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/323

Хэрлэн сум

Урьдчилан сэргийлэх ажилд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.1.3, 32.1.10 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 07 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах, ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулахад 598,000 (таван зуун ерэн найман мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай

3. Ард иргэдэд Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

4. Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг аймгийн гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны
06 дугаар сарын 02-ны өдрийн
01/302 дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

д/д	Нэр төрөл	Хэмжээ /м ² /	Тоо /ширхэг/	Нэгж дүн /төгрөг /	Нийт дүн /төгрөг/
1	"Бэлэн бай" хулдаасан хэвлэл	4*3	1	15.000	180.000
2	"Бэлэн бай" хулдаасан хэвлэл	3*2	2	15.000	180.000
3	"Бэлэн бай" хөөсөнцөр хэвлэл	1*0.8	2	24.000	48.000
4	"Түр цугларах цэг" самбар	0.9*0.9	5	38.000	190.000
Нийт		-	10	-	598.000